



ХЭНТИЙ АЙМГИЙН  
БОР-ӨНДӨР СҮМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2025 оны 02 сарын 26 өдөр

Дугаар А/42

Бор-Өндөр сум

Газар эзэмшүүлэх эрхийн гэрчилгээг  
шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3 дахь хэсэг, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.3, 38.4 дэх хэсэг, Иргэний хуулийн 70.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Холбогдох хууль тогтоомжийн дагуу газар эзэмших эрхийн гэрчилгээг шилжүүлэх тухай нотлох баримт бүрдүүлэн өргөдөл гаргасан иргэний эзэмших эрхийн гэрчилгээг нэгдүгээр хавсралтад зааснаар шилжүүлсүгэй.

2.Газар эзэмших эрхийн гэрчилгээг шилжүүлэн авсан иргэнтэй гэрээ байгуулан, гэрээний биелэлтэд байнгын хяналт тавьж ажиллахыг Газрын даамал (Т.Эрдэнэзаяа) -д үүрэг болгосугай.


3.Газар эзэмших гэрээнд тусгагдсан зориулалт, нөхцлийн дагуу газраа эзэмшин, гэрээний биелэлтийг жил бүр дүгнүүлж байхыг газар эзэмших эрхийн гэрчилгээг шилжүүлж авсан иргэнд үүрэг болгосугай.

4.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2018 оны А/17 тоот захирамжийн "Сувдан зурхай" ХХК-д холбогдох хэсгүүдийг хүчингүй болсонд тооцугай.

ЗАСАГ ДАРГА



Г.АДЪЯАБИЛЭГТ



Газар болон эзэмшигчдийн мэдээлэл

| д/д | Эрх шилжүүлэн авч буй иргэн, хуулийн этгээдийн нэр | Регистр    | Газрын хэмжээ /м <sup>2</sup> | Эзэмших хугацаа | Газрын байршил хаяг                            | Нэгж талбарын дугаар | Зориулалт           | Эрх шилжүүлж буй иргэн хуулийн этгээдийн нэр, регистр | Эрх шилжүүлэх үндэслэл                                        |
|-----|----------------------------------------------------|------------|-------------------------------|-----------------|------------------------------------------------|----------------------|---------------------|-------------------------------------------------------|---------------------------------------------------------------|
| 1   | Дөрвөд далай хаан Даваажав Нансалмаа               | ОТ89052860 | 170                           | 8               | 1-р баг Бор-Өндөр, Худалдаа-1 гудамж, 111 тоот | 2322002178           | Худалдаа, үйлчилгээ | Сувдан зурхай ХХК рд: 4185072                         | Иргэний хуулийн 70.1 дэх заалт, аж ахуйн нэгжийн албан хүсэлт |